

**“ОРОН НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН АЛБАН
ХААГЧДЫН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨЛӨВЛӨЛТИЙГ
САЙЖРУУЛАХ НЬ” ЗӨВЛӨГӨӨН МАНАЙ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.**

Хугацаа: 2022.08.08-2022.08.10-ны өдрүүдэд

Байршил: Говьсүмбэр аймаг

Хамтран зохион байгуулагч: БОАЖЯ, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх” төсөл /NAP in Mongolia/

Тус зөвлөгөөн нь орон нутагт оролцогч талуудыг дэмжлэгтэйгээр үндэсний дасан зохицох төлөвлөлтийн үйл явцыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, орон нутгийн ажлын уялдааг сайжруулах зорилготой 2022 оны 08 дугаар сарын 08-09-ны өдрүүдэд зохион байгуулагдав.

Зөвлөгөөнд БОАЖЯ-ны сайд Б.Бат-Эрдэнэ, БОАЖЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Буяннэмэх, БОАЖЯ-ны Уур амьсгалын өөрчлөлтийн газрын дарга, NAP төслийн захирал, Ш.Цэрэндулам, БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Оюунсанаа, НҮБХХ-ийн БИОФИН II төслийн зохицуулагч Л.Цэрэнням, санхүүгийн зөвлөх З.Баярхүү, “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавхыг бэхжүүлэх” төсөл /NAP in Mongolia/ -ийн хамт олон, аймгийн Засаг даргын орлогч Б.Анхбаяр, 21 аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, мэргэжилтэн, Байгаль хамгаалагч нар нийт 230 гаруй төлөөлөгчид оролцсон.

Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлын үндэсний бодлого, хууль эрх зүйн орчны дүн шинжилгээ, Уур амьсгалын өөрчлөлт, түүний учруулж буй үр дагаварыг бууруулах, орон нутагт авч хэрэгжүүлж буй зарим арга хэмжээний үр дүн хэлэлцүүлэг өрнөсөн.

Мөн НҮБХХ-ийн “Биофин II” төслөөс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Энэ журмын зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.1-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг (цаашид "төлбөрийн орлогын хэсэг" гэх) байгалийн ургамал, ан амьтан, газар, ус, рашаан, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлэх, төсвийн суурь зарлагад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тусгах, зарцуулах, тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2023 оны орлого, зарлагын төлөвлөгөөний явц, анхаарах асуудлаар НҮБХХ-ийн БИОФИН I төслийн зохицуулагч Л.Цэрэнням, санхүүгийн зөвлөх З.Баярхүү нар аймгуудын нийт оролцогчдод мэдээлэл хийсэн.

Технологи бридж ХХК-наас Хог хаягдал /хуванцар сав/ төлбөртэй хүлээн авах автомат машин /ЭКОКЭШ/ танилцуулсан. Энэхүү машин нь мэдээллийн технологийн хамгийн сүүлийн үеийн шийдлүүдийг гудамж талбайд өдөр тутам хэрэглээ болгож, хүрээлэн буй орчны бохирдол, экологийн доройтлыг бууруулахад ач холбогдолтой.

Говьсүмбэр аймгийн БОАЖ-ын газрын ахлах мэргэжилтэн Б.Гандулам төрийн дээд шагнал болох "Хөдөлмөрийн хүндэт" медалиар шагнагдлаа.



